



TASK

Хичээлийнм
гадуурх цагийн
цэцэрлэг нээгдлээ.
БҮРТГҮҮЛЭЭРЭЙ



- ✓ 8 сарын 28-ны 1 дэх өдөр эхэлнэ.
- ✓ Элсэлт эхэлж байна.
- ✓ www.task-kids.com.au веб хуудас руу орж хичээлийн гадуурх цагийн цэцэрлэг гэдэг дээр даран Arncliffe West гэснийг сонгоно уу.
- ✓ өглөө болон үдээс хойш ажиллана.
- ✓ өглөөний болон үдийн цай өгнө.
- ✓ Хичээлийн даалгавраа хийх болон ном уншихад тохирсон нам гүм орчинтой.
- ✓ Дуу хөгжим, зураг, хөгжөөнт тоглоомуудтай.



TASK-ийн талаарх нэмэлт мэдээллийг

www.task-kids.com.au эсвэл **1300 827 500**

Хичээлийн гадуурх цагийн цэцэрлэг(TASK) нь Баруун Арнклиф дэх бага сургуульд хичээлийн гадуурх хүүхэд харах үйлчилгээгээ шинээр эхэллээ.



TASK – хичээлийн гадуурх цагийн цэцэрлэг

(бид өглөө хүүхэд харна!)

8 сарын 28-ны Даваа гаригт эхлэнэ

Манай сургууль өглөөний болон өдрийн цагаар хүүхэд харах анги ажиллуулж эхэлж байгаадаа туйлын таатай байна. Хүүхэд харах клуб буюу англиар TASK нь 8 сарын 28-ны өдрөөс эхлэн AWIS дээр өглөө бүр, үдээс хойш бүр энэхүү үйлчилгээг үзүүлж эхлэх болно.

Элсэлт авч байна

Arncliffe West багачуудын сургуулийн TASK үйлчилгээнд хүүхдээ хэрхэн хамруулах вэ?

1. www.task-kids.com.au веб хуудас руу орж *Arncliffe West Infants* гэдэг дээр даран **enrol** гэснийг сонгох буюу
2. <https://arncliffewest-task.hubworks.com.au> энэ холбоосоор орж **enrol** гэснийг сонгоорой.

Анхаарах зүйлс:

- ✓ Хүүхдийнхээ төрсөн огноо, CRN дугаар зэргийг зөв оруулснаар үнийн хөнгөлөлтөө цаг алдалгүйгээр авах боломжтой байн болно.
- ✓ Хүүхэд тань астма, хурц хэлбэрийн алерги, диабет болон татаж унадаг өвчтэй бол эрүүл мэндийн зааварчлага/удирдамжийг нь веб руу хийж оруулаарай.
- ✓ БҮХ мэдээллийг оруулсны дараа TASK –аас таны e-мэйл хаяг руу элсэлтийг тань бүртгэж авсныг баталсан e-мэйл илгээх болно. Мөн энэхүү e-мэйлээр таныг улсын холбогдох байгууллагуудтай хэрхэн холбогдон буцаан олголтоо авах талаар зөвлөсөн байх болно.
- ✓ enrol@task-kids.com.au руу e-мэйл илгээн сургуулийн нэр, хүүхдийн овог нэр, ямар ямар өдрүүдэд хэдээс хэдэн цагт TASK–д хамрагдах хүсэлтэй байгаа зэргийг мэдэгдээрэй. (мөн хэзээнээс эхлэх тухай бичнэ үү)
- ✓ Эдгээр мэдээллийг хүлээн авсаны дараа бид танд e-мэйл явуулж хүүхдээ хэзээ ямар ангид хамруулахаар бүртгэж авсаныг мэдээлэх болно.

TASK-д хүүхдүүд цагийг яаж өнгөрөөх вэ?

TASK нь бүх хүүхдүүдэд өглөөний болон өдрийн цай бэлтгэн өгөх болно. Хүүхдээ бүртгүүлэхдээ хүүхдийнхээ хоол унданд тавигддаг глютенгүй хоол, халал хоол, ногоон идэштэн, элдэв хүнсний алерги, идэж болохгүй хоол хүнс гэх мэт тусгай шаардлага байдаг бол түүнийгээ мэдээлээрэй.

Эрт өглөөний TASK – өглөөний 07:00-9:30 цагуудад

Өглөөний 7 цагт эхэлсний дараа өглөөний цай өгөх болно. Түүний дараа гадаа/дотор тоглох, зураг зурах, ном унших зэргээр цагийг үр дүнтэй өнгөрөөх болно. Сургууль 09.30-д эхлэхэд ангийн багш нарт нь хүүхдийг тань хүлээлгэн өгөх болно.

Үдээс хойшхи TASK – үдээс хойш 15:30-18:00 цагуудад

Сургуулиа тарангуутаа ирнэ. Хүүхдийг ангийн багшаас нь хүлээн авах болно. Үдийн цай өгсний дараа ном унших, гэрийн даалгавраа хийх, хөгжим, зураг, спорт, урлан бүтээх зэргээр хичээллэх эсвэл найзуудтайгаа гадаа/дотор тоглох болно. 18 цагаас эцэг эхчүүд хүүхдээ “Ягаан өрөө”–нөөс авч болно.

Хэдэн цагт? Ямар үнэтэй вэ??

Цаг	Үнэ
Өглөө (эртэч шувуухай) 07:00-9:30	\$16.50 (before rebate)*
Үдээс хойш 15.30-18:00	\$24.00 (before rebate)*

*ихэнх гэр бүлүүд энэхүү зардлын 50%-ийг нь буцааж авах эрхтэй байдаг. Буцаан олголтын дараа таны эцсийн зардал нь хичээл тутамд нэг хүүхдийн \$5-\$10 байх болно.

Баруун Арнклиф дэх бага сургууль таны гэр бүлийнхэнтэй танилцахыг тэсэн ядан хүлээж байна.

TASK-тай холбогдох - 1300 827 500 - enrol@task-kids.com.au